



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 730.

Улаанбаатар хот

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрөөр тэмцээн уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2015 оны А/433 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр спортын тэмцээн уралдаан, арга хэмжээг 2015 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Чингисийн талбайд зохион байгуулсугай.

2. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн тэмцээн уралдааныг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээн уралдааныг зохион байгуулахад шаардагдах 1.351.000 /Нэг сая гурван зуун тавин нэгэн мянган/ төгрөгийг хуваарилагдсан төсвөөс зохих журмын дагуу гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээн уралдааны урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Батсайханд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500005

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны 05 сарын 28-ны өдрийн
А/30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт


Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрийн тэмцээн уралдааныг
зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Дугуйн тэмцээний тамирчдын шагнал: 4 х2х20000төг = 160.000 төг 4 х2х15000төг = 120.000 төг 4 х2х10000төг = 80.000 төг	360.000
2.	Дугуйн тэмцээний шүүгчдийн ажлын хөлс: /6хүн х 1 өдөр х 20.000 төг/	120.000
4.	Диплом, өргөмжлөл 27х3000=81000	81.000
Дүн		561.000
5.	Сагсан бөмбөгийн тэмцээний тамирчдын шагнал: 8х20000төг = 160.000 төг 8х15000төг = 120.000 төг 8х10000төг = 80.000 төг	360.000
	Сагсан бөмбөгийн тэмцээний шүүгчдийн хөлс: /12хүн х 1 өдөр х 20.000 төг/	240.000
	Диплом, өргөмжлөл 30х3000=90000	90.000
	Тээврийн зардал	100.000
Дүн		790.000
НИЙТ ДҮН:		1.351.000

Боловсруулсан
Хянасан

Б.Батсайхан
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны 15-дугаар сарын 18-ны өдрийн
А/30 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрөөр "Дугуйн тэмцээн"-ийг зохион байгуулах
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|-----------------------|-------------|
| 1. Ерөнхий шүүгч | Б.Батсайхан |
| 2. Нарийн бичиг шүүгч | Ш.Жамбал |
| 3. Шүүгч | Э.Солонго |
| 4. Шүүгч | Д.Адъяа |
| 5. Шүүгч | З.Наран |
| 6. Шүүгч | Б.Заяа |

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрөөр "Сагасан бөмбөгийн тэмцээн"-ийг зохион
байгуулах шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------------|---------------|
| 1. Шүүгч Ерөнхий шүүгч | Б.Мөнх-Орших |
| 2. Нарийн бичиг шүүгч | Б.Батбаатар |
| 3. Шүүгч | Ж.Мөнхбат |
| 4. Шүүгч | У.Болормаа |
| 5. Шүүгч | С.Энхбат |
| 6. Шүүгч | А.Сумъяа |
| 7. Шүүгч | Т.Эрдэнэ-Очир |
| 8. Шүүгч | Д.Энхсайхан |
| 9. Шүүгч | Г.Эрхбаяр |
| 10. Шүүгч | Б.Лхагва |
| 11. Шүүгч | Д.Дэмбэрэл |
| 12. Шүүгч | И.Баттөгс |